



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Г Оноосон нэр сольж үнэт цаасны бүртгэлд Ү
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2 дах заалт, “УСИБ” хувьцаат компанийн 2011 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын ээлжит бус хурлын 01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “УСИБ” ХК-ийн оноосон нэрийг “МҮДИКС” ХК болгон өөрчилж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “МҮДИКС” ХК /Б.Батболд /-д үүрэг болгосугай.

3. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН